

**Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл (MERESP)
IDA CREDIT# P174116**

АЖЛЫН ДААЛГАВАР

Хөдөлмөр, халамжийн үйчилгээний ерөнхий газарт Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “ejob” платформыг хариуцаж ажиллах мэдээллийн технологийн зөвлөх

1. Үндэслэл

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл” нь хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг ажил хайгч болон бичил бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй хүргэх, КОВИД-19 цар тахлын үед зохих шалгуур хангасан ажиллагчдад түр хугацаанд хөнгөлөлт үзүүлэх зорилготой. Төсөл нь дараах үндсэн 4 бүрэлдэхүүн хэсэгтэй.

Бүрэлдэхүүн хэсэг 1: Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагуудтай нягт хамтран ажилласанаар ажил олгогч болон ажил хайгчдад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээг илүү үйлчлүүлэгч төвтэй болгон хөгжүүлэхэд чиглэгдэнэ. Бүрэлдэхүүн хэсэг 2: Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Бүрэлдэхүүн хэсэг 3: Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн цар хүрээ, чанар, хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. Бүрэлдэхүүн хэсэг 4: Зохих шалгуур хангасан ажиллагч, ажил олгогчдын нийгмийн даатгалын шимтгэлийг түр хугацаагаар хөнгөлөх.

Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд дараах үндсэн ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. (a) Хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээний өнөөгийн байдалд хийсэн үнэлгээнд үндэслэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх; (b) **Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем (LMIS) болон мэдээллийн технологийн дэвшилтэд технологид суурилсан ажил зуучлалын үйлчилгээг нэвтрүүлэх** (c) Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ)-ын мэдээллийн систем, сургалтын орчиныг сайжруулж, байр/танхимыг засварлан тохижуулах; (d) Техникийн туслалцаа, боловсон хүчнийг сургах замаар төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх.

ХНХЯ-аас Монгол Улсын Засгийн газрын Шинэ сэргэлтийн бодлого, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем LMIS-ыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд “eJob платформ”-ын ажил зуучлалын онлайн порталыг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр нээж, улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлсэн. Платформ нь ажил зуучлалын онлайн портал, гар утасны аппликейшнаас гадна ХНХЯ, хэрэгжүүлэгч агентлаг болох ХХҮЕГ-н хэрэгжүүлдэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг үзүүлэх мэргэжилтнүүдийн ажиллах 3 дэд систем, 13 модулиас бүрдсэн.

Онлайн портал болон гар утасны аппликейшнаар дамжуулан ажил олгогчид ажлын байрны захиалга өгөх, ажил хайгчид мэдээлэл авах, өөрийн CV-ээ оруулж ажил хайгчаар бүртгүүлэх, ажилд зуучлуулах боломжтой.

Ажилд зуучлах үйлчилгээнээс гадна хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, төсөл хөтөлбөрт хамрагдах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд бүртгүүлэх, ажилгүйдлийн тэтгэмж авах мөн төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээтэй холбоотой санал, гомдлоо цахимаар илгээж шийдвэрлүүлэх боломжтой.

“eJob” платформын нэг дэд систем болох гар утасны аппликейшныг Android болон iOS үйлдлийн систем дээр суулгах боломжтой бөгөөд ажил хайгч, ажил олгогчид ашиглана.

Түүнчлэн ХНХЯ-аас хэрэгжүүлдэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг үзүүлэх мэргэжилтнүүдийн үйл ажиллагаа, чиг үүргийг автоматжуулсан. Ингэснээр ажилтнуудын ачааллыг багасгаж, захиргааны зардлыг бууруулж, ажлын гүйцэтгэл, бүтээмжийг нэмэгдүүлнэ.

2024 оны 02 дугаар сарын байдлаар “Ejob” платформд:

- Бүртгэлтэй ажлын байрны тоо – 93,496
- Ажил хайгчийн тоо – 84,274
- Ажил олгогчийн тоо – 11,689
- Ажилд зуучлагдсан иргэдийн тоо – 24,894
- Мобайл аппликэйшн хэрэглэгчийн тоо – 48,929 байна.

Энэхүү системийг цаашид үр дүнтэй ашиглах, нэмэлт хөгжүүлэлт сайжруулалтыг хийж үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг бүрэн үзүүлэхэд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Мэдээллийн технологийн төвийн одоогийн байгаа ажиллах хүч нь орон тооны дутагдалтай, системийн үйл ажиллагааг хариуцаж байгаа нэг мэргэжилтэнтэй. Түүнчлэн систем нь нэмэлт сайжруулалт, хөгжүүлэлтийн шатандаа явж байна.

Дээрхээс үндэслэн ХНХЯ нь системийн жигд ажиллагааг хангах, гарсан алдаа доголдлыг цаг тухайд нь шийдвэрлэх буюу зарим жижиг нэмэлт сайжруулалт хийх зэрэг үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд ХНХЯ, ХХҮЕГ-т техникийн туслалцаа үзүүлэх мэдээллийн технологийн зөвлөхийг ажиллуулахаар төлөвлөж байна.

| | |
|---|---|
| <p>Үйл ажиллагааны хамрах хүрээ:</p> | <p>Зөвлөх нь "ejob" платформыг хариуцаж ажиллах бөгөөд дараах үйл ажиллагааны хүрээнд ажиллана. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Гүйцэтгэгч компани болон бусад “eJob” платформын оролцогч талуудтай нягт хамтран ажиллах; 2. Системд гарч байгаа алдаа доголдуудыг илрүүлэх, техникийн асуудлуудыг тодорхойлох, гарсан алдааг засварлах; 3. “eJob” платформ болон гар утасны аппликейшн түүний мэдээллийн сангийн хэвийн, тасралтгүй ажиллагааг хангах; 4. “eJob” платформ болон гар утасны аппликейшнд хэрэглэгчийн шаардлагын дагуу нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалт хийх; 5. DocMine¹, Keycloak², K2³, Fine Report⁴, Профайлинг⁵ гэх мэт холбогдох бусад системүүд дээр шаардлагатай хөгжүүлэлт хийх; 6. Системийг сайжруулах талаар шинэ санал санаачлагыг гаргах, танилцуулах; 7. “eJob” платформтой холбогдож ажиллах бусад байгууллага, систем, өгөгдлийг тодорхойлох, холбох; 8. Төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтнууд “eJob” платформыг ашиглахтай холбоотой гарсан хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх, заавар зөвлөгөөгөөр хангах; 9. "ejob" платформтой холбоотой мэдээ мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор инфографик болон постер бэлтгэх; |
| <p>Шаардагдах ур чадвар, туршлага:</p> | <p>А. Мэргэшсэн байдал</p> <ul style="list-style-type: none"> • Програм хангамжийн инженер, мэдээллийн системийн чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй; <p>В. Туршлага</p> <ul style="list-style-type: none"> • Мэдээллийн технологийн чиглэлээр 8 жил ажилласан туршлагатай байх, үүнээс 5 жил программ хангамж, вебд суурилсан мэдээллийн системийн хөгжүүлэлтийн чиглэлээр ажилласан байх; • Гар утасны аппликейшн хөгжүүлэлтийн туршлагатай байх; • Системийн дизайн, хөгжүүлэлт, хэрэгжилт, системийн туршилт, салбар дундын мэдээллийн сангийн менежмент, бизнесийн автоматжуулалтын системийг хөгжүүлэх чиглэлээр ажилласан туршлагатай байх; • Төрийн байгууллагын мэдээллийн технологийн хөгжүүлэлтийн чиглэлээр тодорхой ажлын туршлагатай байх; |

¹ Бичиг баримтын програм (Дотоодын)

² Keycloak -Open Source Identity and Access Management : Хэрэглэгчийн бүртгэл, бүлэг болон хандах эрх зэргийг бүртгэнэ.

³ K2-Category and classification service програмаар системийн бүх параметрийг тохируулна. “eJob” платформын дэд системүүдийг K2 платформ дээр хөгжүүлсэн.

⁴ Fine Report програм хангамжаар тайланг хөгжүүлсэн.

⁵ Хөдөлмөр эрхлэх үр чадварын үнэлгээ/Профайлингийн бизнесийн үйл ажиллагааг автоматжуулсан.

| | |
|--|--|
| | <ul style="list-style-type: none"> • Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чиглэлийн системийн нэвтрүүлэлт болон хөгжүүлэлт дээр ажиллаж байсан бол давуу тал болно; • Өгөгдлийн сан зохион байгуулах, холбох болон системийн интеграци хийх, төрийн мэдээлэл солилцооны ХУР, ДАН системийн мэдлэг, туршлагатай байх; <p>С. Ур чадвар</p> <ul style="list-style-type: none"> • Angular, Flutter, React технологийн өндөр ур чадвар, туршлагатай байх; • Spring boot, Elastic search, Apache kafka ашиглах чадвартай байх; • K2, Finereport, Keycloak ашиглаж байсан туршлагатай байх; • MySQL, MSSQL өгөгдлийн сангийн өндөр мэдлэгтэй байх; • Tableau, Power BI системүүд дээр ажиллах чадвартай байх; <p>D. Бусад шаардлага</p> <ul style="list-style-type: none"> • Харилцааны өндөр ур чадвартай байх; • Багаар ажиллах чадвартай байх; • Бизнесийн үйл явцад дүн шинжилгээ хийх, технологийн шийдэл гаргах чадвартай байх; • Асуудлыг шийдвэрлэх өндөр ур чадвартай байх; • Төслийн хэлэлцүүлэг/шинжилгээнд оролцох чадвартай байх; • Шинэ технологид суралцах, судалгаа, шинжилгээ хийх чадвартай байх; • Англи хэлний ярианы болон бичгийн чадвартай байх; • Ажлын цагаар оффист сууж ажиллах боломжтой байх; |
| <p>Явцын тайлан, үр дүнг хянах:</p> | <p>Зөвлөх нь ХНХЯ, ХХҮЕГ болон ТХН, Дэлхийн банкны удирдлаган дор ажиллана. Мэдээллийн технологийн зөвлөх нь ХНХЯ/ТХН болон ХХҮЕГ-ын Мэдээллийн технологийн төвд сар бүр тайлагнана. Тайланд системд гарсан алдаа, тулгарсан асуудлыг шийдвэрлэж засварласан, нэмэлт хөгжүүлэлт, мөн системийг цаашид сайжруулахад хийх шаардлагатай санал, зөвлөмжийг тусгана.</p> <p>Зөвлөхийн үйл ажиллагааг дараах үзүүлэлтүүдээр үнэлнэ:</p> <ul style="list-style-type: none"> - Ажлын даалгаварт тусгасан ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн байдал; - Нийлүүлэх үр дүнг заасан хугацаанд гүйцэтгэсэн байдал; - Гүйцэтгэсэн ажлын чанар; |
| <p>Тайлагналт болон төсөв:</p> | <p>Зөвлөх нь ХНХЯ/ХХҮЕГ, ТХН болон Дэлхийн банкинд тайлагнана.</p> |

| | |
|---------------------------------------|--|
| <p>Нийлүүлэх бүтээгдэхүүн:</p> | <p><u>Нийлүүлэх бүтээгдэхүүн:</u> Сар бүр гүйцэтгэсэн үндсэн ажлын тайлан. Нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалт хийж, гарсан техникийн алдаа, тулгарсан асуудлыг шийдвэрлэж засварласан байдал, цаашид анхаарч хэрэгжүүлэх шаардлагатай санал, зөвлөмж. Тайланг сар бүрийн 25-нд ирүүлнэ.</p> |
| <p>Гэрээний хугацаа:</p> | <p>Зөвлөх нь 2024 оны 04-р сарын 01-ээс 2024 оны 12-р сарын 31 хүртэл ажиллана. Нийт 9 сарын хугацаанд ХХҮЕГ-ын оффист байрлан бүтэн цагаар ажиллана.</p> |
| <p>Төсөв:</p> | <p>Гэрээний нийт үнийн дүн 48,600,000 төгрөгөөс хэтрэхгүй.</p> |
| <p>Төлбөрийн нөхцөл:</p> | <p>Төлбөрийг дараах байдлаар хувааж төлнө. 2024 онд: Төлбөрийг зөвлөхийн сарын ажлын тайланг хүлээн авч, баталснаас хойш 9 сарын турш төлнө. Төлбөрийг сар бүр олгох бөгөөд ажлын гүйцэтгэлээр сарын төлбөр 5,400,000 төгрөг.</p> |